


Баянзүрх дүүргийн Засаг даргын  
2017 оны 11 дүгээр сарын 14-ны  
өдрийн 11275 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

**Зорилго:** Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, орчны тохижилт, гадна фасад, зар сурталчилгааны байгууламж, хаягийн байгууламжийн өнгө үзэмжийн байдал болон нийтийн аж ахуйн чиглэлээр хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах зөрчилтэй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцож ажиллах.

**Хугацаа:** Байнгын

**Хамрах хүрээ:** Дүүргийн нутаг дэвсгэр

Хамтран оролцох байгууллага: Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, их дээд болон ерөнхий боловсролын сургуулиуд, Цэргийн анги нэгтгэлүүд, Төрийн бус байгууллагууд, СӨХ, иргэд, оролцоно.

**Ажлын хэсгийн зохион байгуулалт:**

1. Дүүргийн нэгдсэн ажлын хэсгийг байгуулах ба энэхүү ажлын хэсгийн дор дэд ажлын хэсгүүд байгуулж, ажлын хэсэг бүрт гудамж хуваарилах байдлаар зохион байгуулна.

2. Ажлын хэсэгт орж ажиллаж байгаа ажилтан, албан хаагч ажлаас чөлөөлөгдөх, өөр албан тушаалд шилжих тохиолдолд тухай ажлын байран дээр ажиллах дараагийн ажлын хэсэгт орж ажиллана.

**Ажиллах хуваарь:**

№	Байгууллагын нэр	Хариуцах чиглэл
	Засаг даргын Тамгын газар	1. Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хяналт шалгалтын ажлын хэсгүүд байгуулж, ажиллах 2. Аж ахуйн нэгж, байгууллагуудад уриалга гаргаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах 3. Үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагуудыг олонд сурталчилж мэдээлэх 4. Хороодыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, удирдамжийн хэрэгжилтийн дүнг тооцож ажиллах
	Мэргэжлийн хяналтын хэлтэс	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтын удирдамж, Засаг даргын Тамгын газартай хамтран тогтмол хяналт, шалгалт явуулж, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах Хууль, тогтоомж, шаардлага биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох
	Хороод	Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад нэгдсэн удирдамжийн талаар тогтмол мэдээлэл хүргэж ажиллах Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудын худалдаа, үйлчилгээний гэрээний хэрэгжилтийг хангуулах